



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/498

Хэрлэн сум

Олон нийтийг соён гэгээрүүлэх үйл
ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022
оны 10 дүгээр сарын 04-ны
А/498 дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

| № | Үйл ажиллагааны нэр | Зарцуулах мөнгөн дүн |
|----------|---|----------------------|
| 1 | Эрх бүхий албан тушаалтны багийг төрийн зарим байгууллагуудад тусгай удирдамжийн дагуу ажиллуулж дотоод хяналт хийх | 1,500,000 |
| 2 | Цахим орчин болон орон нутгийн телевизээр нэвтрүүлэх шторк, нэвтрүүлэг хийх | 1,000,000 |
| 3 | Эссэ бичлэгийн болон гар зургийн уралдаан зарлаж бүтээлүүдийг олон нийтэд сурталчлан таниулах | 2,500,000 |
| Нийт дүн | | 5,000,000 |